

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

---

2008 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

“Урт хугацааны даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн хэмжээ, түүнд тавигдах шаардлага” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.1, 14.2.4, 25.2, 25.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Урт хугацааны даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн хэмжээ, түүнд тавигдах шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ДҮРМИЙН САН БОЛОН НӨӨЦ  
САНГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ХӨРӨНГИЙН  
ХЭМЖЭЭ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 болон Даатгалын тухай хуулийн 14.2.4, 25.2, 25.3 дахь заалтуудын дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэнэ)-ноос урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд (цаашид “даатгагч” гэх)-ийн дүрмийн сан болон нөөц сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад зохистой харьцаагаар оновчтой байршуулахад оршино.

1.2.Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулах зорилго нь даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, нөөц сангаас даатгуулагч нарт даатгалын гэрээний дагуу олгох нөхөн төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхүйц найдвартай, баталгаатай байлгахад оршино.

1.3.Даатгалын тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан урт хугацааны сангийн зохицуулалт энэ журамд үл хамаарна.

**Хоёр.Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага**

2.1.Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд дараах шаардлагууд тавигдана:

2.1.1.Даатгагч нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөр баталгаажуулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй байх ба уг төлөвлөгөөнд энэхүү журмын 3.1-д заасан зүйлийг тусгасан байна;

2.1.2.Даатгагч нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон түүнийхээ биелэлтийг Хороонд жил бүр ирүүлж байна;

2.1.3.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг энэхүү журмын 4.1, 4.3, 5.1 болон 5.4-т заасан хязгаарлалтын хүрээнд боловсруулсан байна;

2.1.4.Хорооны 2008 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.1.3-т заасан учирч болзошгүй хохирлын нөөц сангаас энэ журамд заасны дагуу хөрөнгө оруулалт хийж болно;

2.1.5.Даатгагч нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг Монгол Улсын хилийн чанадад эрхлэх тохиолдолд гагцхүү Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэж болно.

2.2.Хэрэв даатгагч нь Монгол Улсын хилийн чанадад хөрөнгө оруулалт хийхийг хүсвэл энэ тухай хүсэлтээ Хороонд албан бичгээр ирүүлж, зөвшөөрөл авна.

**Гурав. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө**

3.1.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

3.1.1.Энэ журмын 4.1 болон 5.1-т заасан хязгаарлалт дээр үндэслэсэн тухайн компанийн хөрөнгө хуваарилалтын байдал;

3.1.2.Энэ журмын 4.3 болон 5.4-т заасан хөрөнгө оруулалтын хувь хэмжээ;

3.1.3.Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн зохистой харьцаа;

3.1.4.Даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй бусад эрсдэлийг удирдах талаар;

3.1.5.Даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг нөхөн барагдуулах зорилгоор даатгагч нь хөрөнгө оруулалтад байршуулсан хөрөнгийг шуурхай татан төвлөрүүлж, хохирлыг барагдуулах талаар;

3.1.6.Хөрөнгийн үнэлгээг зөв тодорхойлсон байх, хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны үеийн үнэлгээг тооцоолж тусгах;

3.1.7.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд даатгалын компанийн актуарчийн тухайн санхүүгийн жилд даатгалын сангуудтай холбоотой даатгагчийн хүлээсэн үүрэгт гарсан өөрчлөлт болон холбогдох үзүүлэлтийг үнэлж тооцсон талаар;

3.1.8.Хөрөнгө оруулах гэж буй хөрөнгийн өгөөжийн талаар.

3.2.Даатгалын компанийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулалтыг ТУЗ-өөс баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

3.3.ТУЗ нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, эрсдэлийн удирдлага, мэдээлэл, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөндлөнгийн аудитын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллана.

### **Дөрөв. Нөөц сангийн хөрөнгө оруулалт**

4.1.Даатгагч нь тухайн тайлант жилд байгуулсан учирч болзошгүй хохирлын нөөц сангийн 40 хувийг компанийн тусгайлсан дансанд байршуулна. Энэхүү учирч болзошгүй хохирлын нөөц сангийн үлдэх 60 хувийг болон учирч болзошгүй хохирлын хуримтлагдсан нөөц санг 100 хувь энэхүү журмын 4.3-т заасны дагуу хөрөнгө оруулалтад байршуулж болно.

4.2.Нөөц сангаас урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт хийж болно.

4.3.Энэ журмын 4.1-д заасан тухайн тайлант жилд байгуулсан учирч болзошгүй хохирлын нөөц сангийн 60 хувь болон учирч болзошгүй хохирлын хуримтлагдсан нөөц сангийн дараахи хувь хэмжээгээр хөрөнгө оруулалтад байршуулж болно:

4.3.1.Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;

4.3.2.Төв банкны үнэт цаас: 100 хүртэл хувь ;

4.3.3.Банкны хадгаламж: 80 хүртэл хувь;

4.3.4.Орон нутгийн засаг захиргааны бонд: 80 хүртэл хувь;

4.3.5.Банкны хадгаламжийн сертификат: 70 хүртэл хувь;

4.3.6.Компанийн бонд: 60 хүртэл хувь;

4.3.7.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас: 60 хүртэл хувь;

4.3.8.Бусад төрлийн санхүүгийн хэрэгсэл: 10 хүртэл хувь.

### **Тав. Дүрмийн сангийн хөрөнгө оруулалт**

5.1.Даатгалын тухай хуулийн 22.1-д заасан даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээний 20 хувийг дараахь шаардлага хангасан банкны (нэг буюу хэд хэдэн банкинд байж болно) хадгаламжинд “заавал байршуулах нөөц” хэлбэрээр байршуулна. Дүрмийн сангийн үлдэх 80 хувийг хөрөнгө оруулалтад байршуулж болно.

5.1.1.Тухайн банкны хувь нийлүүлэгч буюу хувьцаа эзэмшигч биш байх;

5.1.2.Хадгаламж нээлгэж буй банк нь тухайн даатгалын компанийн нэгдэлд ороогүй байх;

5.1.3.Хорооноос заасан тусгайлсан дансанд байршуулсан дүрмийн сангийн 20 хувийг зөвхөн тухайн даатгалын компани төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд даатгалын гэрээний явцад үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор ашиглана.

5.2.Дүрмийн сангаас урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт хийж болно.

5.3.Энэ журмын 5.1-д заасан дүрмийн сангийн 80 хувийг дор дурдсан хувь хэмжээгээр хөрөнгө оруулалтад байршуулж болно:

5.3.1.Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;

5.3.2.Төв банкны үнэт цаас: 100 хүртэл хувь;

5.3.3.Банкны хадгаламж: 80 хүртэл хувь;

5.3.4.Орон нутгийн засаг захиргааны бонд: 80 хүртэл хувь;

5.3.5.Банкны хадгаламжийн сертификат: 70 хүртэл хувь;

5.3.6.Компанийн бонд: 60 хүртэл хувь;

5.3.7.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас: 60 хүртэл хувь;

5.3.8.Үл хөдлөх хөрөнгө: 30 хүртэл хувь;

5.3.9.Бусад төрлийн санхүүгийн хэрэгсэл: 10 хүртэл хувь.

## **Зургаа. Хөрөнгө оруулалт болон заавал байршуулах нөөцөд тавих хяналт**

6.1. Даатгагчийн хөрөнгө оруулалтын болон заавал байршуулах нөөцийн үйл ажиллагаанд Хороо хяналт тавина.

6.2. Даатгагч нь хөрөнгө оруулалтын болон заавал байлгах нөөцийн тайланг Хорооноос баталсан маягтын дагуу гаргаж, Хороонд улирал тутам ирүүлнэ.

### **Долоо. Хүлээлгэх хариуцлага**

7.1. Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг биелүүлээгүй болон заавал байршуулах нөөцийг дутагдуулсан даатгалын компанийн албан тушаалтныг Даатгалын тухай хуулийн 83.1.32-т заасны дагуу 50 000-100 000 төгрөгөөр, даатгагчийг 500 000-1 000 000 төгрөгөөр тус тус торгоно.

7.2. Заавал байршуулах нөөцийн доод хэмжээг 3 сараас дээш хугацаагаар үргэлжлүүлэн хангаагүй буюу хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг удаа дараа биелүүлээгүй даатгагчид ногдуулах албадлагын арга хэмжээний тухай санал боловсруулан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

--ooOoo--